

**ДАРХАН-УУЛ АЙМАГТ 2023 ОНД ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

2024.02.29

Дархан-Уул аймаг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн гадаадын зээл тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн гадаад зээл тусламж төслүүдийн үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцлоо.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Дархан-Уул аймагт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, нийт 9 төсөл, хөтөлбөрийг 90, 7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж, хэрэгжилтийн хувь **95.55** буюу **4.77** онооны үнэлгээтэй байна.

3.1. Гадаад зээл тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга

Үнэлгээ	Чиглэл	Бүгд	Төслийн нэр								
			Төсөл 1	Төсөл 2	Төсөл 3	Төсөл 4	Төсөл 5	Төсөл 6	Төсөл 7	Төсөл 8	Төсөл 9
Төслийн тоо		9	1	1	1	1	1	1	1	1	1
Үр дүнтэй буюу 100%		7		1	1	1		1	1	1	1
Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%		1	1								
Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%		1				1					
Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50%											
Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%											
Хэрэгжилтийн хувь		95.55%	90	100	100	100	70	100	100	100	100
Хэрэгжилтийн оноо		4.77 оноо	4.5	5.0	5.0	5.0	3.5	5.0	5.0	5.0	5.0

Төслийн хүрээнд хамтран ажиллагч байгууллагуудад 101 ажлын байр шинээр бий болж 14 салбарын 1224 иргэнд цахим болон танхимаар хослуулан сургалт зохион байгуулж чадавхижуулсан байна.

3.2. Хөрөнгө оруулалтын ангилалаар:

Хөрөнгө оруулалтын төрөл	2019		2020		2021		2022		2023		
	Төгрөг	Доллар	Төгрөг	Доллар	төгрөг	Доллар	Төгрөг	Евро	Төгрөг	Доллар	Евро
Тэтгэлэгт хөтөлбөр	149.1				36.02						
Буцалтгүй тусламж	2,646.2	104.2	544.9		0.42		7,219.18		17941.01		3,000.0
Зээл	108,756.0		3,986.7		10,385.3	1,000.0		18.023		18.023	
Төсөл	20.9		63.0		133.5		2,324.2				
Дүн	1,430.1	104.2	5300.0		10,563.14	1,000.0	9543.38	18.023	17,941.01	18,023.0	3,000.0

3.3. Төслүүдээр авч үзвэл:

№	Төслийн нэр	Төгрөг /сая/
1	960-н хүүхдийн эко сургууль /Дархан-Уул, Дархан сум 12-р баг/	13287.8
2	Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл /Дархан-Уул аймаг, Дархан сум, 7-р цэцэрлэг 1.Барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг сайжруулах./	60.05
3	Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл /Дархан-Уул аймаг, Дархан сум, 7-р цэцэрлэг, 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв./	159.44
4	Хоол тэжээлийн хөтөлбөр /Дархан-Уул, Дархан, 7-р цэцэрлэг./	44.55
5	"НАЙРАМДАЛ" Дархан-Уул аймгийн нийгэм, эдийн засгийн шинэлэг, тэгш хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжин Европын Холбоо-Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх төсөл	3,000.0
6	Зуны зуслан цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, /Дархан-Уул, Дархан, 7-р цэцэрлэг/	29.14
7	Дархан хотын Бохир усны менежментийг сайжруулах төсөл МОН3244/3245	18,023.0
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга	4300.0
9	Хүүхдийн ариун цэврийн өрөө, цахилгаан хангамж, халаалт, халуун усны узелийн засварын ажил /Дархан-Уул, Дархан, 3-р цэцэрлэг	60.03
	Евро	3,000.0
	Доллар	18,023.0
	Төгрөг	17,941.01
	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ,%	95.55% буюу 4.77 оноо

3.4. Төслийн хэрэгжилт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт:

2023 оны төсвийн жил 15072.26 сая төгрөг. /Монгол банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ам доллартай харьцах төгрөгийн ханш/. Төсвийн жилийн гүйцэтгэлийн задаргааг хүснэгтээр харуулбал:

2023 оны төсвийн жил /мян.төгрөг/			Үүнээс:			
Дүн	Төсөв	Гүйцэтгэл	ТХН-ийн үйл ажиллагааны зардал	Дотоод зөвлөх үйлчилгээ	Гадаад зөвлөх үйлчилгээ	Хөрөнгө оруулалт
Төгрөг	15,072,267.18	13,792,961.09	-	2,193,096.14	-	11,599,864.95

Төслийн хэрэгжилтийн хүрээнд гэрээ сунгалтын талаар 9 төслөөс 3 төсөл арга хэмжээ гэрээ сунгасан бөгөөд 1 төсөл 1 удаа 4 сараар, 1 төсөл 4 удаа 48 сараар, 1 төсөл 5 удаа 42 сараар сунгалт хийж, 6 төсөл бүрэн хэрэгжсэн.

2023 онд зээл олгож, батлан даалт гарган, санхүүгийн үйлчилгээг өссөн дүнгээр 14 аж ахуйн нэгж байгууллага, 1,266.16 сая төгрөг зарцуулсан байна.

3.5. Төслийн төлөвлөсөн ажил, сургалтын талаар:

Төслийн төлөвлөсөн ажлын биелэлт бүрэлдэхүүн хэсгийн тоо 24, бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх ажлын тоо 112, биелэлт 91.0% буюу 4.55 онооны үнэлгээтэй байна.

Нийт сургалтын тоо 176, хамрагдах хүний тоо 9316. Үүнээс: 158 сургалтыг цахим болон танхимаар хослуулан нийт 8452 иргэнд зохион байгууллаа. 2023 онд шинээр 134 ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс 139 байнгын ажлын байр шинээр бий болгож, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын биелэлт **90.0%** буюу 4.5 оноотой байна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ:

МУЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан журмын дагуу, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.2.1-д заасан аргачлалын дагуу үнэлгээг хийхэд **95.55%** буюу **4.77** оноотой байна.

Үнэлгээг төлөвлөгөөний дагуу жилд 1 удаа хийх бөгөөд аймгийн нэгдсэн тайланд хэрэгжилтийн танилцуулгыг тусгаж байна. Төслийн тайланг Сангийн яамны батлагдсан маягт хүснэгт 1-7 дагуу гаргалаа.

ТАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Төслийн тайланг хариуцсан албан хаагч хугацаанд нь батлагдсан маягтын дагуу тоон мэдээлэл, мөнгөн дүнгүүдийг зөв тусган, үнэн бодит мэдээ гарган, аймгийн эдийн засагч, санхүүгийн албаны даргаар хянуулан, хэлтсийн даргаар дүнгээ баталгаажуулан ирүүлэх.
2. Батлагдсан маягыг өөрчлөхгүй, орхигдуулахгүй бүрэн гүйцэт бөглөж ирүүлэх.
3. Санхүүжилтийг төгрөг, евро, долларыг зөв шилжүүлж, шилжүүлэх боломжгүй бол төгрөг, доллар, еврогоор нь тодорхой бичиж зөв дүн ирүүлэх шаардлагатай.
4. Тухайн онд хэрэгжиж байгаа төслүүдийг орхигдуулахгүй, төслийн ажилтны тоогоо тусгах.

5. Өмнөх оны гарсан тайлантай харьцуулан, хөрөнгө, санхүүгийн зарцуулалтыг тулгаж, шалган бодитоор гаргах.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА О. ХҮРЭЛЧУЛУУН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА П. БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г. ГЭРЭЛМАА